



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 27 өдөр

Дугаар А/804

Арвайхээр

Ажлын хэсэг томилох тухай

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7, 14 дүгээр зүйлийн 14.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны А/84 дүгээр тушаалаар батлагдсан “Согтууруулах ундааны үйлдвэрийн төсөл сонгон шалгаруулах, үйлдвэрлэлд хяналт тавих журам”-ын 4.3, 4.4, 4.5, 4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн төсөл сонгон шалгаруулах, үйлдвэрлэлд зөвшөөрөл олгох, сунгах, түтгэлзүүлэхэд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Ариунаа -аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний албаны дарга

Нарийн бичгийн дарга: Н.Дулам -аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэр, худалдаа, үйлчилгээний бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд: Б. Энхтуяа -аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч

С.Дагиймаа -аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй, халдвар, хамгааллын хяналтын улсын байцаагч

З.Түмэндэмбэрэл -аймгийн Татварын хэлтсийн Татварын орлогын тасгийн татварын улсын байцаагч

Н.Өлзийхутаг -аймгийн Цагдаагийн газрын Нийтийн хэв журам сахиулах тасгийн ахлах байцаагч


Ч.Рэнчинбямба -аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн хяналтын улсын байцаагч

С.Пагамзүгсмаа -аймгийн Засаг даргын дэргэдэх Стандарт, хэмжил зүйн хэлтсийн Баталгаажуулалтын шинжээч

Б.Энхболд -аймгийн Засаг даргын дэргэдэх Стандарт, хэмжил зүйн хэлтсийн улсын шалгагч

2. Холбогдох журам, стандартын дагуу согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, дүгнэлтийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт тус тус хүргүүлж ажиллахыг ажлын хэсэг (Ц.Ариунаа)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г. ГАНБОЛД

011101115